



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр

Дугаар 353

Улаанбаатар хот

Дуудлагын худалдааг дахин зохион
байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 44 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 22,956,125.00 (хорин хоёр сая есөн зуун тавин зургаан мянга нэг зуун хорин таван) төгрөгийн балансын үнэ бүхий автомашины 3 дахь дуудлагын худалдааг зохион байгуулахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Диспетчерийн үндэсний төв” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Д.Балдорж нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих захиргааны актын дагуу байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2018 оны 06 дугаар сарын ... ний өдрийн
 ... дугаар тогтоолын хавсралт



"Диспетчерийн үндэсний төв"
 төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн
 үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, дахин нээлттэй
 дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашины марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиг лалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	ТӨБЗГ-ын 2017 оны 298 дугаар тогтоолоор тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)	Шинэчлэн тогтоосон худалдах доод үнэ (төгрөг)
1	"Хьюндай Старекс", 36-12 УБӨ, суудлын, KMjWWN7jP6074 2068	2007	260294	22,956,125.00	5,000,000.00	2,500,000.00
	Нийт дүн			22,956,125.00 (хорин хоёр сая есөн зуун тавин зургаан мянга нэг зуун хорин таван)	5,000,000.00 (таван сая)	2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган)